

Төсөл

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД,
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2024 оны ... дугаар
... сарын . . .-ны өдөр

Дугаар.....

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хүүхэд хамгааллын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 23 дугаар зүйл, 23.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Боловсролын сургалтын байгууллага болон сүм хийдийн орчны аюулгүй байдалд нөхцөл байдлын үнэлгээ хийх журам”-ыг нэгдүгээр, “Боловсролын сургалтын байгууллага болон сүм хийдийн орчны аюулгүй байдлын өөрийн үнэлгээний асуумж”-ийг хоёрдугаар хавсралтаар, “Боловсролын сургалтын байгууллага болон сүм хийдийн орчны аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө”-г гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газар /...../-т, Боловсролын яамны Бодлогын хэрэгжилтийн газар /...../-т тус тус даалгасугай.

3.Энэхүү тушаалыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД

Л.ЭНХ-АМГАЛАН

БОЛОВСРОЛЫН САЙД

П.НАРАНБАЯР

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын
сайд, Боловсролын сайдын 2024 оны ...
дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар
хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралт

БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА, СҮМ ХИЙДИЙН ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛД НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Боловсролын сургалтын байгууллага болон сүм хийдийн орчны аюулгүй байдалд нөхцөл байдлын үнэлгээ хийх харилцааг Хүүхэд хамгааллын тухай хууль /шинэчилсэн найруулга/, Боловсролын ерөнхий хууль, Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, энэ журмаар зохицуулна.

1.2.Боловсролын сургалтын байгууллага болон сүм хийдийн орчны аюулгүй байдалд нөхцөл байдлын үнэлгээ хийх үйл ажиллагааны зорилго нь хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхдэд тулгарах болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийг хангах, хүүхдийг гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхгүй байх орчныг бүрдүүлж ажиллах, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхэд чиглэнэ.

1.3.Энэхүү журам нь Боловсролын Ерөнхий хуулийн 18.1-ийн дагуу боловсролын сургалтын байгууллага болох цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллеж, коллеж, дээд сургууль, их сургууль болон насан туршийн суралцахуйн төв, сүм хийдийн шашны сургуульд тус тус хамаарна.

1.4. Боловсролын сургалтын байгууллага болон сүм хийдийн орчны аюулгүй байдалд нөхцөл байдлын үнэлгээ хийхдээ нийгэм сэтгэл зүйн орчин, харилцаа болон материаллаг орчныг үнэлнэ.

Хоёр. Боловсролын сургалтын байгууллага болон сүм хийдийн орчны аюулгүй байдалд нөхцөл байдлын үнэлгээний хэлбэр, багийн бүтэц, зохион байгуулалт

2.1.Байгууллагын орчны аюулгүй байдалд нөхцөл байдлын үнэлгээг өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний хэлбэртэйгээр зохион байгуулна.

2.2.Байгууллагын удирдлага нь өөрийн үнэлгээний багийг багш, ажилтан, эцэг эхийн төлөөлөл, суралцагчдын төлөөлөл бүхий 7-оос 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулна. Багийн гишүүдээс ажлын туршлага, манлайлах чадвар зэргийг харгалзан багийн ахлагчийг томилно.

2.3.Байгууллагын удирдлага болон хүүхэд хамгааллын багаас өөрийн үнэлгээний багийн гишүүдэд хүүхэд хамгаалал, орчны аюулгүй байдлын талаар холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд сургалт зохион байгуулж, мэдлэг олгоно..

2.4. Өөрийн үнэлгээний багийн чиг үүрэг:

2.4.1 Хүүхэд хамгааллын тухай хуулийн 23.2.9-ийн дагуу сургалтын орчны нөхцөл байдлын зураглал гарган, эрсдэлийн үнэлгээг улирал тутам хийж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг гаргаж, батлуулах, хэрэгжүүлэх

2.4.2. “Боловсролын сургалтын байгууллага болон сүм хийдийн орчны аюулгүй байдлын өөрийн үнэлгээний асуумж”-аар (Хавсралт 2) үнэлгээг хийнэ.

2.4.3.Боловсролын сургалтын байгууллага болон сүм хийдийн орчны аюулгүй байдлыг хангах төлөвлөгөөг (Хавсралт 3) хийнэ.

2.4.4. Боловсролын сургалтын байгууллага болон сүм хийдийн орчны аюулгүй байдалд нөхцөл байдлын үнэлгээ хийсэн тухай тайланг үнэлгээ хийсэн баг нь байгууллагын удирдлага болон удирдлагын багт танилцуулна.

2.4.5. Үнэлгээний үр дүн, тайланг байгууллагын эцэг эхийн зөвлөлд танилцуулж, тайлагнана.

2.4.6. Өөрийн үнэлгээний баг нь байгууллагаас орчны аюулгүй байдалд нөхцөл байдлын үнэлгээний дагуу авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг үр дүнг үнэлнэ.

2.5.Боловсролын сургалтын байгууллага болон сүм хийдийн орчны аюулгүй байдалд нөхцөл байдлын үнэлгээг тухайн хичээлийн жилийн эхэнд болон төгсгөлд хоёр удаа хийнэ.

2.6. Байгууллагын удирдлага өөрийн үнэлгээний багийн танилцуулга, үнэлгээний дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналд тулгуурлан төлөвлөгөө гарган ажиллана.

2.7. Боловсролын сургалтын байгууллага болон сүм хийдийн орчны аюулгүй байдалд нөхцөл байдалд хийх хөндлөнгийн үнэлгээг байгууллагын удирдлага нь холбогдох мэргэжлийн байгууллагаар үнэлүүлж, дүгнэлтийг хавсаргана. Үүнд:

2.7.1 Галын аюулгүй байдлын дүгнэлт

2.7.2 Эрүүл ахуйн байцаагчийн дүгнэлт

Гурав. Хяналт, хариуцлага

3.1.Үнэлгээний үр дүн, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар байгууллагын удирдлагын багаас багш, ажилтнуудад, суралцагчдад болон эцэг эхийн төлөөлөлд танилцуулж, баримтжуулсан байна.

3.2.Боловсролын сургалтын байгууллага, сүм хийдийн орчны аюулгүй байдалд нөхцөл байдлын үнэлгээг улирал тутам хийж байгаа эсэх, журмын хэрэгжилтэд орон нутгийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага аймгийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтэстэй хамтран хяналт тавина.

4.3.Боловсролын сургалтын байгууллага болон насан туршийн суралцахуйн төв нь орчны аюулгүй байдалд нөхцөл байдлын үнэлгээ хийсэн тухай тайлангаа харьяа аймаг, дүүргийнхээ Боловсролын хэлтэст хичээлийн шинэ жилийн эхэнд болон төгсгөлд тайлагнана.

4.4.Сүм хийдийн шашны сургууль нь орчны аюулгүй байдалд нөхцөл байдлын үнэлгээ хийсэн тухай тайлангаа аймаг, дүүргийнхээ Хүүхэд гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор тайлагнана.

Дөрөв. Санхүүжилт

4.1.Орчны аюулгүй байдлын нөхцөл байдлын үнэлгээг хийх, хэрэгжүүлэхтэй холбоотой гарах санхүүжилтийг тухайн байгууллага жилийн төсөвт зардлыг тусгаж ажиллана.

ТӨСӨЛ

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд,
 Боловсролын сайдын
 2024 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
 ... дугаар хамтарсан тушаалын хоёрдугаар хавсралт

**БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА БОЛОН СҮМ ХИЙДИЙН
 ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АСУУМЖ**

Байгууллагын нэр:.....	Үнэлгээ хийсэн огноо:
------------------------	--------------------------------

ХЭСЭГ А. НИЙГЭМ, СЭТГЭЛ ЗҮЙ, ХАРИЛЦААНЫ ОРЧИН

Энэхүү хэсэгт хүүхдийн аюулгүй байдал, хамгааллын орчныг үнэлэх бөгөөд хүүхдэд тулгарч болох аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн хамгаалагдах эрх зөрчигдсөн тохиолдолд үзүүлэх үйлчилгээ, хүний нөөц бий эсэхийг үнэлнэ.

Үнэлгээний асуумжийг ТИЙМ/ҮГҮЙ/ХАМААРАХГҮЙ гэсэн байдлаар үнэлнэ. ҮГҮЙ гэж хариулсан бол тухай асуудлыг шийдвэрлэх арга хэмжээний саналыг гаргана.

Тухайн асуудал нь байгууллагын чиг үүрэгт хамааралгүй үзүүлэлт байвал ХАМААРАХГҮЙ гэсэн хариултыг сонгоно.

Үнэлгээний төгсгөлд үгүй гэсэн хариултыг сонгосон хэсэгт гарсан асуудал, түүнийг хэрхэн шийдвэрлэх талаар дүгнэлтээ бичнэ.

ТИЙМ	ҮГҮЙ	ХАМААРАХГҮЙ	ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АСУУМЖ
			Хүүхэд хамгааллын бодлоготой.
			Хүүхэд хамгааллын багтай.
			Хүүхэд хамгааллын бодлогын тухай болон бодлог зөрчигдвөл хаана, хэнд хандахыг тодорхой заасан мэдээллийг хүүхдэд ээлтэй байдлаар хана, танхимд байрлуулсан.
			Хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтийг хариуцсан ажилтантай. Түүнд хандахаа хүүхдүүд мэддэг.
			Гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд холбогдсон болон хохирогч хүүхдийг хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамруулдаг.
			Хүүхдийг хорт зуршил, согтуурах, мансуурах, донтох байдалд өртөхөөс урьдчилан сэргийлэх сургалтыг хүүхдийн нас, бие, хөгжлийн онцлогт тохируулан, улирал тутам явуулдаг.
			Эцэг эхчүүдэд хүмүүжлийн зэрэг аргын зөвлөгөөг өгч, сургалтад хамруулдаг.
			Хүүхдүүдээс эрсдэлт нөхцөлд байгаа эсэхийг үнэлэх асуумж, судалгаа авдаг.

			Хүүхэд хоорондын, хүүхэд, багш, ажилтан, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хоорондын харилцаанаас үүсэн зөрчлөөс сэргийлэх дүрэмтэй, түүнийг ил байрлуулсан.
			Сургуулийн хүүхэд хамгааллын багийн гишүүд болон нийгмийн ажилтан, сэтгэл зүйчтэй уулзахад хувийн болон эмзэг мэдээллийг хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдоод задруулахгүй гэдгийг суралцагчид мэддэг. Энэ талаарх мэдээллийг хүүхэд бүр мэддэг.
			Хүүхэд тодорхойгүй шалтгаанаар хичээлдээ ирээгүй тохиолдолд гэр бүл, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид нэн даруй мэдэгддэг. Түүнийгээ баримтжуулдаг.
			Багш, ажилтан нь хүүхэд эрсдэлт нөхцөлд өртсөн талаар мэдсэн, таамагласан, илрүүлсэн бол хүүхэд хамгааллын багийн ахлагч захирал, гишүүн нийгмийн ажилтан эсхүл хүүхэд хамгааллын хариуцсан ажилтанд заавал мэдээлэх үүрэгтэйг баталгаажуулж гарын үсэг зуруулсан.
			Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрын орчин, үйлчилгээнд тавигдах шаардлагыг хангасан.
ХЭСЭГ Б. МАТЕРИАЛЛАГ ОРЧИН			
Энэхүү хэсэгт байгууллагын аюулгүй байдал, хамгааллыг үнэлнэ. Өөрөөр хэлбэл гадаад буюу материаллаг орчин нь хүүхдийн аюулгүй байдал, хамгааллыг хангасан эсэхийг үнэлнэ.			
Үнэлгээний асуумжийг өмнөхийн адил ТИЙМ/ҮГҮЙ гэсэн байдлаар үнэлнэ. ҮГҮЙ гэж хариулсан бол тухай асуудлыг шийдвэрлэх арга хэмжээний төлөвлөгөө ажиллана.			
Тухайн асуудал нь байгууллагын чиг үүрэгт хамааралгүй үзүүлэлт байвал ХАМААРАХГҮЙ гэсэн хариултыг сонгоно.			
ТИЙМ	ҮГҮЙ	ХАМААРАХГҮЙ	ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АСУУМЖ
			Сургалт, хүмүүжлийн орчны эрүүл ахуйн шаардлагыг хангасан. MNS 6799:2019
			Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлагыг хангасан.
			Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчны стандартыг хангасан.
			Байгууллагын барилга байгууламж нь ашиглалтын шаардлага хангасан, газар хөдлөлтөд тэсвэртэй.

		Барилга нь суралцагчдад ээлтэй бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэн, суралцагчдад ээлтэй, тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн.
		Байгууллагын хашаа нь 1,6 м-ээс доош өндөртэй, хурц үзүүргүй, бат бөх бэхэлгээтэй, авирахад аюулгүй.
		Байгууллагад онцгой байдал, эмнэлэг, цагдаагийн тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл нэвтрэх боломжтой.
		Байгууллагын гадна, дотор орчинд стандартын шаардлага хангасан хяналтын камертай. Хяналтын камер ажиллуулах, мэдээллийн нууцлалыг хангах дотоод журамтай. Дээрэлхэлт болж болох орчин, булан, шатны хонгил зэрэгт камерыг байршуулсан
		Гэрэлтүүлэг бүрэн.
		Суралцагч унаж бэртэхээс хамгаалсан цонхны хамгаалалт, хязгаарлалтын түгжээтэй.
		Байгууллагын орчны замын хөдөлгөөнд хурд сааруулагч, аюулгүйн тэмдэг, тэмдэглэгээтэй.
		Байгууллагын орчны нөхцөл байдлын зураглал гаргасан.
		Хог хаягдал түр хадгалах цэг нь хана, хашаагаар тусгаарлагдсан хаалттай, битүүмжлэлтэй. Хогоо ангилж хаях боломжтой, хогоо ангилж хийх зориулалт бүхий тэмдэг, тэмдэглэгээтэй.
		Галын аюулаас хамгаалсан, гал унтраах хэрэгсэлтэй, хэрэглэх заавартай.
		Аюулгүйн гарцтай, аваар ослын үед барилгаас гарах хөдөлгөөнийг харуулсан зураг, схемтэй, аваарын гэрэл, дохио тэмдэглэгээг гарц бүрд байрлуулсан.
		Анги, танхимын агаар MNS 4585:2016 стандартын шаардлагыг хангасан, харьцангуй чийгшилт 40-өөс 60 хувь байна. Анги, танхим бүр цонхтой, цонх бүр салхивчтай, аюулгүйн хамгаалалттай. Анги, танхим бүрд агаарын хэм, чийгшил хэмжих хэрэгсэлтэй.
		Байгууллага, анги, танхимын цахилгаан хангамжийн аюулгүй байдлыг хангасан, гэрлийн унтраалга, цахилгаан тэжээлийн залгуур бүрэн бүтэн, хэвийн ажиллагаатай.
		Ариун цэврийн өрөө нь стандартын шаардлага хангасан, эрэгтэй/эмэгтэй өрөөтэй, гар угаалтууртай. Шал нь халтирдаггүй,

		зориулалтын материалтай. Жорлон, угаагуур нь байнгын устай. Суултуур, шээлтүүрийн тоо хүрэлцээтэй, хоорондоо тусгаарлагчтай, суралцагчдын насанд тохирсон.
		Байгууллагын гадна, дотор шал халтирахгүй, ширээ, шат, толинд булангийн хамгаалалттай. Хаалганы шил доргилт, цохилтот тэсвэртэй.
		Анги, танхимд ундны устай, MNS 0900:2018 шаардлагыг хангасан, хадгалж буй сав нь эрүүл мэндэд эрсдэлгүй, хүнсний зориулалттай материалаар хийсэн. Зориулалтын ус цэвэршүүлэгч төхөөрөмж нь 75 суралцагчийн дунд нэг байна.
		Байгууллагын танхим, коридорт байрлуулсан толь, самбар нь эрсдэлгүй, сайтар бөхлөгдсөн, ирмэг, булангийн хамгаалалттай.
		Хувцасны өлгүүртэй, өлгүүр нь бэхэлгээтэй, хувцас өлгөх дэгээ нь хурц үзүүргүй. Нэгдсэн өлгүүр нь гэрэлтүүлэгтэй, орох гарахад саадгүй, суралцагч эрсдэлд өртөхөөргүй байна.
		Гадна талбайн тоног төхөөрөмж хэрэглэгдэхүүн нь аюулгүй, бэхэлгээтэй, унаж бэртэхээс хамгаалагдсан, аюулгүй байдлыг хангасан.
		Ширээ сандал нь суралцагчдын нас, биеийн онцлогт тохирсон, эрүүл ахуйн шаардлагыг хангасан. Шүүгээ тавилгыг ханатай бэхэлж, хөдөлгөөнгүй байршуулсан, ирмэгийн хамгаалалтыг хийсэн.

Боловсролын сургалтын байгууллага болон сүм хийдийн орчны аюулгүй байдлын үнэлгээний дүгнэлт:

Үнэлгээ хийсэн:

1.
2.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд,
Боловсролын сайдын
2024 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
... дугаар хамтарсан тушаалын гуравдугаар хавсралт

**БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА БОЛОН СҮМ ХИЙДИЙН ОРЧНЫ
АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Энэхүү маягт нь Боловсролын сургалтын байгууллага болон сүм хийдийн орчны аюулгүй байдлын нөхцөл байдлын үнэлгээний хэрэгжилтийг хянаж үнэлэхэд зориулсан. Энэхүү маягтыг нь маягт 1-ийг бөглөсний дараа үнэлгээ хийсэн баг болон оролцогч талуудыг оролцуулан бөглөнө.

Боловсролын сургалтын байгууллага болон сүм хийдийн орчны аюулгүй байдлын нөхцөл байдлын үнэлгээний үйл ажиллагааны хяналт, үнэлгээг хийхэд ашиглана.

Байгууллагын нэр:							
Огноо:							
№	Үнэлгээгээр асуудлууд	гарсан	Авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хариуцах эзэн	Хугаца а	Нөөц/төсө в	Биелэлт
ХЭСЭГ А. НИЙГЭМ СЭТГЭЛ ЗҮЙН ОРЧИН, ХАРИЛЦААНЫ ОРЧИН							
1.							
2.							
3.							
ХЭСЭГ Б. БАЙГУУЛЛАГЫН МАТЕРИАЛЛАГ ОРЧИН							
1.							
2.							
3.							